



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/268

Есөнбулаг сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төгрөг сумын иргэн Д.Буянхишгийн 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр аймгийн Засаг даргад ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хууль, эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

